

САЛБАРЫН БОДЛОГО ШИЙДВЭР .....	2
1. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль	
2. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
4. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
5. Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль	
6. Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	
7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль	
8. Нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт оруулах тухай хууль өөрчлөлт оруулах тухай хууль	
9. “Хүүхэд бүрт мөнгө олгох тухай” Засгийн газрын 2007 оны 43 дугаар тогтоол	
10. Засгийн газрын “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр батлах тухай” 2007 оны 109 дүгээр тогтоол	
11. Засгийн газрын “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2007 оны 354 дүгээр тогтоол	
12. Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 2007 оны 351 дүгээртогтоол	
13. Засгийн газрын “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн тухай” 2007 оны 355 дугаар тогтоол	
14. Засгийн газрын “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2007 оны 350 дугаар тогтоол	
ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН .....	51
• Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын 2007 оны үйл ажиллагааны үр дүнгээс	
ТАНЫ ТАНИН МЭДЭХҮЙД .....	57
• Байгалийн сэргээгдэхгүй нөөцийн орлогын зохистой менежмент - тусгай сан	
АСУУВАЛ, ХАРИУЛЪЯ .....	62

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр** зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 19 дүгээр зүйл:

**“19 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн** тэтгэмж авах эрх

19.1. Дор дурдсан иргэн нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрхтэй:

19.1.1. Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;

19.1.2. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие мах бодийн хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

19.1.3. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл, садангийн хүнгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

19.1.4. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны.

19.2. Энэ хуулийн 19<sup>1</sup>.1-д заасан иргэнийг асаргаа, сувилгааны болон гэр бүлдээ авч асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулна. Сургалтыг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлаас санхүүжүүлнэ.

19.3. Энэ хуулийн 19<sup>1</sup>.2-т заасан сургалтыг зохион байгуулах журам болон сургалтын хөтөлбөрийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2/ 6 дугаар зүйлийн 5, 8, 9, 10 дахь хэсэг:

“6.5. Нийгмийн ажилтны ажлын ачааллын жишиг нормативыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн

газрын гишүүн тогтооно.

6.8. Нийгмийн халамжийн мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1-д заасан байгууллага хэрэгжүүлнэ.

6.9. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамж үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагын үйл ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, нөхцөлт мөнгөн тэтгэмж, мөнгөн тусламж болон нийгмийн халамжийн зориулалттай хөрөнгийн, зээлийн, хандивын зарцуулалтад хяналт тавих, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах саналаа энэ хуулийн 6.8-д заасан байгууллагад тавих чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байж болно.

6.10. Аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан ажилтантай байж болно.”

3/9 дугээр зүйлийн 2, 3, 6, 7, 8,9 дахь хэсэг:

“9.2. Энэ хуулийн 3.1.2-т зааснаас бусад иргэнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай эсэхийг амьжиргааны түвшинг нь харгалзан Зөвлөл тогтооно. Амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн хороо хамтран батална.

9.3. 2000-аас дээш хүн амтай баг, тосгонд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Зөвлөл ажиллуулж болно.

9.6. Зөвлөлийн шийдвэр нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.

9.7. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох зайлшгүй зардлыг халамжийн сангаас санхүүжүүлнэ.

9.8. Зөвлөлийн гишүүнд болон сум, хорооны нийгмийн ажилтанд ажлын оролцоо, идэвх чармайлтыг харгалзан улиралд нэг удаа урамшуулал олгож болно. Урамшууллын хэмжээ, олгох журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.9. Энэ хуулийн 9.8-д заасан зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.”

4/10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“10.5. Нийгмийн ажилтан Төрийн албаны тухай хуулийн 27.1-д заасан баталгаанаас гадна дор дурдсан нөхцөл, баталгаагаар

хангагдана:

10.5.1. Ажлын онцлогоос шалтгаалан тусгай өрөө, эсхүл тусгаарлалт бүхий ажлын байр болон шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдах;

10.5.2. Сум, хороонд 25 ба түүнээс дээш жил ажилласан нийгмийн ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол 12 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа байгууллагаасаа авах.”

5/13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт:

“13.2.6.3 өвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил болон халамжийн үйл ажиллагааны зардал.”

6/17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“17.1.4. Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхдийн халамжийн тэтгэвэр.”

7/18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

“18.1.6. Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд.”

8/19 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6, 7 дахь заалт:

“19.1.5. Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж;

19.1.6. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие мах бодийн хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж;

19.1.7. Ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж.”

9/ 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“25.2. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно:

25.2.1. Гурав хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа;

25.2.2. Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа;

25.2.3. Гурав ба түүнээс дээш тооны бага насны хүүхэдтэй /14 хүртэлх насны/ өрх толгойлсон эх /эцэг/-д жилд нэг удаа;

25.2.4.18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд болон гэнэтийн аюул, ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр авахад нь дэмжлэг үзүүлж нэг удаа.”

10/ 28 дугаар зүйлийн 1 хэсгийн 4 дэх заалт:

“28.1.4. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн.”

**11/ 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:**

“28.2.4. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхэд.”

12/28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“28.3. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг 4 нас хүртэл нь төрийн зардлаар асрамжилна.”

13/ 30 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“30.3.Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах, асрамжийн газрыг магадлан итгэмжлэх болон асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн гарчигийн “тогтолцоо” гэсний дараа “хяналт”, 9.4-ийн “дүрмийг” гэсний өмнө “ажиллах”, 10.3.2-ын “тусламж” гэсний өмнө “амьжиргаанд дэмжлэг үзүүлэх”, 13.2.5-ын “ганц бие” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ганц бие”, 15.2-ын “байгууллага” гэсний өмнө “төв”, 18.1.3-ын “одой” гэсний өмнө “16 насанд хүрсэн”, 26.3-ын “хөгжлийн бэрхшээлтэй” гэсний дараа “хүүхэд ба”, 27.1-ийн “үйлчилгээ” гэсний өмнө “тэдгээрийг олгох журам, 26 дугаар зүйлд заасан”, 31.4-ийн “иргэний” гэсний өмнө “амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламжид хамрагдах”, 35.1-ийн “тогтоолгосон,” гэсний дараа “амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламж,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн дараахь зүйлийн хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 7, 8 дахь заалт:**

“3.1.1.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд энэ хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг “нийгмийн халамж” гэнэ;

~~/3.1.1 мөрдөж буй хууль тогтоомж, журам, зааврын дагуу нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, тэдгээрийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг “нийгмийн халамж” гэнэ;~~

3.1.2. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, түүнчлэн 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн, олон хүүхэдтэй, өрх толгойлсон эх /эцэг/-ийг “нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүн” гэнэ;

~~/3.1.2.тэжээн тэтгэх төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганиц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон ядуу, нэн ядуу амьдралтай олон хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-ийг “нийгмийн эмзэг бүлэг” гэнэ;~~

3.1.3. Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, бусдын асрамжид байнга байгаа хүнийг “байнгын асаргаа шаардлагатай иргэн” гэнэ;

~~/3.1.3.Үндэсний статистикийн газар, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан аргачлалын дагуу судлахад ядуу, нэн ядуу амьдралтай болох нь тогтоогдож, түүнийг нь Амьжиргааг дэмжих зөвлөл баталсан бол тухайн өрх, иргэнийг “ядуу, нэн ядуу өрх, иргэн” гэж тооцно;/~~

3.1.7. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, бүтэн өнчин, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хучирхийллийн улмаас сэтгэл санааны, бие махбодийн хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг

асрамжилж байгаа иргэнд тодорхой шалгуур, болзолтой олгох мөнгөн тусламжийг “нөхцөлт мөнгөн тэтгэмж” гэнэ;

~~/3.1.7 ядуу, нэн ядуу иргэний нэн тэргүүний хэрэгцээг хангах, амьжиргааг нь дэмжих зорилгоор тодорхой шалгуур, болзолтойгоор олгох мөнгөн тусламжийг “нөхцөлт мөнгөн тэтгэмж” гэнэ;/~~

3.1.8. Иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор энэ хуулийн 3.1.2, 3.1.3-т заасан хүнд үзүүлж буй дэмжин туслах үйлчилгээг “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” гэнэ;”

~~/3.1.8. хувь хүн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор нийгмийн эмзэг бүлгийн нэн тэргүүний хэрэгцээг тодорхойлох, хангах, амьжиргааг дээшлүүлэх, дэмжин туслах, сэргээн засах үйлчилгээг “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” гэнэ;/~~

2/8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“8.4.Энэ хуулийн 8.3-т заасан иргэн, байгууллагыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэж, гэрчилгээ олгоно. Тэдгээрийн нийгмийн халамж, асрамжийн уйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөв, халамжийн сангаас гэрээний үндсэн дээр хэсэгчлэн буюу бүрэн санхүүжүүлж болно.”

~~/8.4.Энэ хуулийн 8.3-т заасан иргэн, байгууллага нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээлийн нэгдсэн сүлжээнд хамрагдсан байх бөгөөд тэдгээрийн зардлын зарим хэсгийг орон нутгийн төсөв, халамжийн сангаас гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.~~

3/ 9 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“9.1.Энэ хуулийн 3.1.2-т заасан хүнийг нийгмийн халамжид хамруулахаар тодорхойлох, шийдвэр гаргах үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх сум, хороонд ажиллана.”

~~9.1.Нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлох үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл сум, хороонд ажиллана~~

4/18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“ 18.1.4. Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;”

~~/18.1.4 энэ хуулийн 18.1.3-т зааснаас бусад хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан, бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн;/~~

5/ 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

“25.1.2. Орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт;

25.1.2. орон сууцны хөлс болон түлшний үнийн хөнгөлөлт;

“ **6/ 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“26.1.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ дараахь төрөлтэй байна:”

~~26.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн эмзэг бүлгийн халамжийн үйлчилгээ дараахь төрөлтэй байна.~~

7/ 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт:

“26.2.5. Байнгын асаргаа шаардлагатай иргэн 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн, 3 ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг”

~~26.2.5.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь зогсоогдсон эмзэг бүлгийн иргэн.~~

**4 дүгээр зүйл.**Нийгмийн халамжийн тухай хуулийн 10,3,1-ийн-”нийгмийн эмзэг бүлгийн болон ядуу өрх,” гэснийг “нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх”, 13.2.2-ын “нийгмийн эмзэг бүлгийн” гэснийг “нийгмийн халамжийн туслалцаа шаардлагатай өрх, иргэний”, 16.1 дэх хэсгийн “бүртгэл” гэснийг “мэдээ”, 18.1.1-ийн “садангүй” гэснийг “садангийн хүнгүй”, 25 дугаар зүйлийн гарчгийг “Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжийн төрөл”, 25.1-ийн “Нийгмийн эмзэг бүлэгт” гэснийг “Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд”, 27.1-ийн “Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх иргэнд үзүүлэх” гэснийг

“Энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан”, 24.1, 34.1-ийн “Улсын Их Хурал” гэснийг “Засгийн газар”, 31.4-ийн “жагсаалтыг” гэснийг “жагсаалт, дэвтэр, маягтын загварыг”, 6.5, 6.6 дахь хэсгийн дугаарыг “6.6”, “6.7”, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсгийн дугаарыг “9.4”, “9.5”, 9 дүгээр зүйлийн “9.4” дэх хэсгийн дугаарыг “9.10” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 10.3.3-аас “нийгмийн эмзэг бүлгийн”, 10.3.4-ээс “нийгмийн эмзэг бүлэг, ядуу, нэн ядуу өрх”, 13.2.5-ын “нэн ядуу”, 18.1.1, 18.1.2, 18.1.5-аас “нэн ядуу амьдралтай”, 18.1.3-аас “бүрэн хараагүй, хэлгүй, дүлий,” 26.2-оос “ядуу, нэн ядуу амьдралтай”, 26.2.2-оос “хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан”, 26.3-аас “хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан”, “25.1.1-д заасан тусламжид халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь зогсоогдсон эмзэг бүлгийн иргэн” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 21, 22 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5, 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй;

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

“5.1.8. нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;”

2/ 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“5.3. Энэ хуулийн 5.1.3-т заасан хөнгөлөлт, тусламжид хамрагдах ахмад настныг тухайн орон нутгийн ахмадын байгууллагын саналыг харгалзан Амьжиргааг дэмжих зөвлөл тодорхойлж, шийдвэрлэнэ.

3/ 8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“8.6. Энэ хуулийн 8.5-д заасан “Ахмадын сан” байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1-ийн “ортопедийн хэрэгсэл” гэсний дараа “худалдан авсан болон”, 5.1.4-ийн “ахмад настан” гэсний өмнө “ахмад настан болон эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай”, мөн заалтын “дотоодын” гэсний өмнө “магадлан итгэмжлэгдсэн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, мөн хэсгийн 10 дахь заалтын 3 дахь дэд заалт:

“ 5.1.3. тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд болон хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

*5.1.3. нэн ядуу амьдралтай ахмад настан орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;*

5.1.10.3. орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;”

*/ 5.1.10.3. орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх. /*

2/ 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“8.5. Энэ хуулийн 8.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан төсөвт байгууллага үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс, аж ахуйн нэгж, байгууллага үлдэгдэл ашгаас цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулна.”

*8.5. Энэ хуулийн 8.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан аж ахуйн нэгж, байгууллага бүр цалингийнхаа нийт сангийн 3 хүртэл хувиар “Ахмадын сан” байгуулна.*

**4 дүгээр зүйл.** Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1-ийн “хийлгэх нэг удаагийн зардал” гэснийг “хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутам нэг удаа нөхөн”, мөн зүйлийн 5.1.6-ийн “Авто тээврийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр” гэснийг “орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй”, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 9, 10 дахь заалтын дугаарыг “9.”, “10.”, “11.”, “5.1.10.1.”, “5.1.10.2.”, “5.1.10.3.” гэсэн дэд заалтуудын дугаарыг “5.1.11.а.”, “5.1.11.б.”, “5.1.11.в.”, 8 дугаар зүйлийн “6” дахь хэсгийн дугаарыг “7” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.4-ийн “нэн ядуу амьдралтай, түүнчлэн”, 5.1.5-ын “нэн ядуу” гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5, 8, 9, 10 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5.1.9-5.1.13 дахь заалт:

“5.1.9. Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.10. Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;

5.1.11. Бүрэн хараагүй хүн эмнэлэгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай болвол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.12. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

5.1.13. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэн нас барвал тууний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгох.

2/5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

5.6.Орон гэргүй бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гэр олгох, орон сууцны нөхцөл сайжруулах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг Засгийн газар тухайн жилийн улсын төсөвт тусгана.”

3/ 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“8.4. Аж ахуйн нэгж, байгууллагад хараагүй хүнийг ажиллуулах ажлын байрны жагсаалтыг Засгийн газар батална.”

**4/ 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалт:**

“9.3.7.Хараагүй хүнд зориулсан брайль болон томруулсан үсэгтэй ном, сурах бичиг, сонин, сэтгүүл хэвлэх зардлыг нийгмийн халамжийн сангаас гаргах.”

5/10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг :

“10.2. Аймаг, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нарийн мэргэжлийн /дотор, мэдрэл, мэс засал, ерөнхий эмч/, нийгмийн даатгалын магадлагч эмч, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын болон ажил олгогчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.”

**2 дугаар зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.4-ийн “ортопед,” гэсний өмнө “болон худалдан авсан”, мөн заалтын “үнийг” гэсний дараа “5 жил тутам нэг удаа 100 хувь”, 5.1.6-ийн “эрхийн бичгийн” гэсний өмнө “нэг талын унааны зардалД 7.1-ийн “эрхтэй” гэсний дараа “бөгөөд тэдгээрийг бүх шатны боловсрол эзэмшихэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.”, 7.8-ын “байгууллагын” гэсний дараа “удирдах болон”, 9.3.2-ын “орчуулгатай гаргах” гэсний дараа “урсгал мэдээлэл явуулах, бичгэн мэдээллийг хараагүй хүнд зориулж нэвтрүүлэгч унших”, 10.3-ын “иргэн” гэсний өмнө “хүүхэд ба” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйл:

“6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сэргээн засалт

~~/6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие эрхтэний сэргээн засалт/~~

6.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хүн нийгмийн харилцаанд оролцох, өөрөө өөртөө үйлчилж сурах, бие даан хөгжих чадвар эзэмших зорилгоор сэргээн засах үйлчилгээнд хамрагдах эрхтэй. Сэргээн засах үйлчилгээ нь эрүүл мэнд, мэргэжил, боловсрол, хөдөлмөр, нийгмийн болон сэтгэл зүйн гэсэн төрөлтэй байна.

~~/6.1 Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, чийрэгжих, өөрөө өөртөө үйлчилж сурах, хөдөлмөрлөх чадвартай болох зорилгоор үйл ажиллагаа нь алдагдсан эрхтэнээ сэргээх, солиулах зэргээр сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах эрхтэй./~~

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээг сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг эмчилгээ, сувилгааны, сургалтын байгууллага болон протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж үзүүлнэ.

~~/6.2.Сэргээн засах эмчилгээ, үйлчилгээг эмчилгээ сувилгаа, сургалт, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа болон протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага эрхэлж болно./~~

6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засах үйлчилгээг иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, зардлыг хэсэгчлэн буюу бүрэн санхүүжүүлж болно.”

**1/1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.1.Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцлийг бүрдүүлэх, тэдний өвөрмөц хэрэгцээнд

түшиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх, энэ талаар иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

~~1.1. Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний нөхцөл, хамрах хүрээ, хэмжээг тогтоох, энэ талаар иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.~~

### 3/3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“3.1. Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно.”

~~3.1. Төрөлхийн болон удамиллын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж ойлгоно.~~

### 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

“5.1.1. Бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;”

~~5.1.1. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, нэн ядуу амьдралтай өрхөд орон сууцны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад нь жилд нэг удаа олгох мөнгөн тусламж;~~

### 5/10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг :

“10.1. 16 Насанд хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комисс, 16 насанд хүрсэн иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тус тус тогтооно.

~~10.1. Иргэн хөгжлийн бэрхшээлтэй болохыг нь түүний оршин суугаа аймаг, дүүргийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.~~

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.”

~~/10.2.Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар бүртгэж үнэмлэх олгоно./~~

**4 дугаар зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.2-ын “хоёр удаа” гэснийг”3 жил тутам нэг удаа”, 5.1.3-ын “эхний удаа” гэснийг “5 жил тутам нэг удаа”, 5.1.3, 5.1.4-ийн “нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй” гэснийг “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хиилгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй”, 5.1.5-ын “харах, сонсох, ярих боломж нь хязгаарлагдмал сурагч” гэснийг “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд”, 5.1.6-ын “нэн ядуу амьдралтай өрхийн” гэснийг “эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй”, 5.1.7-ийн “нэн ядуу амьдралтай өрхийн” гэснийг “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон”, 5.1.8-ын “иргэнтэй өрхийн суурин телефон утасны төлбөрт” гэснийг “иргэний харилцаа холбооны зардалд”, 5.2-ын “Авто тээврийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу” гэснийг “орон нутгийн харъяалал харгалзахгүйгээр”, 7.5-ын “энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг аймаг, дүүргийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “хүүхэд ба иргэнийг эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс”, 11.3.1-ийн “шийдвэр гаргах, эсхүл уг асуудлаар дээд шатны байгууллагад” гэснийг “асуудлаар холбогдох байгууллагад”, 10.2,10.3,10.4,10.5 гэсэн хэсгийн дугаарыг “10.3,10.4,10.5,10.6.” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.3-ын “хоёр дахь удаа 50 хувь”, 5.1.4-ийн “ядуу амьдралтай өрхийн”, 5.1.7-ийн “4 хүртэлх насны”, 5.1.8-ын “ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй,” 5.2-ын “буюу хөнгөлөлттэй үнээр”, 9.3.2-ын “мэдээллийн” гэснийг тус тус хассугай.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/ “12 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулах**

12.1. Хөдөлмөрийн зах зээлд бие даан оролцох боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор байгуулагдсан хөдөлмөр сургалтын төв, аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай цех, тасгийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

12.2. Хөдөлмөр эрхлэлтийн алба нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирох ур чадварыг сорилын аргаар тодорхойлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.

12.3. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу шалгаруулна.”

2/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“3.1.7. “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1 дэх хэсэгт заасан хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадварыг нь хөдөлмөр эрхлэлтийн албанаас сорилын аргаар тодорхойлсон иргэнийг;”

3/ 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт :

“4.2.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрлөх тэгш боломжийг хангах.”

4/ 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалт:

“5.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;”

5/ 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“8.5. Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба нь ажилд зуучлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил олгогчтой гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.”

### **6/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7 дахь заалт:**

“9.1.6. Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

9.1.7. Сургууль завсардсан, насанд хүрээгүй хүн.”

7/11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“11.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 24 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшууллыг ажиллуулсан хугацааг харгалзан олгоно.”

### **8/15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт:**

“15.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;”

9/ 22 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“22.5. Ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд улирал тутам мэдээ, тайлан ирүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.2.Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн;”

~~11.1.2.хөгжлийн бэрхшээлтэй болох нь холбогдох журмын дагуу тогтоогдсон бөгөөд хөдөлмөрийн чадвараа 50-аас дээш хувиар алдсан иргэн;~~

**3 дугаар зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7.1-ийн “хангах” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх”,

12.2-ын “цэвэрлэх” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай зориулалтын зам, орц, гарцыг барих”, 10.1-ийн “эрхлэгчид” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй иргэнд” гэж тус тус нэмсүгэй.

**4 дугаар зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн “5.3.4” гэсэн заалтын дугаарыг “5.3,5” гэж өөрчилсүгэй

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/111 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг:

“11.1.6. Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө.

11.1.7. Аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхлэх боломжтой ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 111.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/111 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“1.11.3. Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, төлбөрийн нийт хэмжээнээс хамааран Засгийн газраас тогтооно.”

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 9, 18 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

“9.6, Олон нийтийн радио, телевизийн мэдээллийн болон сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нь дохионы хэлний орчуулгатай тарах ба урсгал мэдээлэл явуулах, бичгэн мэдээллийг хараагүй иргэнд зориулан нэвтрүүлж байна.

2/18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

18.5. Энэ хуулийн 18.1-д заасан үйлчилгээний хөлснөөс бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий иргэнтэй өрх чөлөөлөгдөнө.”

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЭХ ХҮҮХДЭД ТЭТГЭМЖ ОЛГОХ, ХҮҮХЭД, ЭХ,  
ГЭР БҮЛ МӨНГӨН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 2, 8, 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулга бүхий хэсгийг нэмсүгэй;

1/ 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг :

“2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.”

2/ 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“8.4. Энэ хуульд заасан тэтгэмж олгох, мөнгөн тусламж үзүүлэх журмыг Засгийн газар батална.”

3/ 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг :

“9.3. Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр энэ хуульд заасан тэтгэмж, мөнгөн тусламж тогтоолгосон гэм буруутай этгээдээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хохирлыг нөхөн төлүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 4.6-ын тэтгэмж” гэсний дараа “4.3-д заасан мөнгөн тусламж”, 4.4-ийн “авах эрхтэй.” гэсний дараа “Хэрэв эх хүүхдээ төрүүлсний дараа нас барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй.”, 4.7-ийн “тэтгэмж” гэсний дараа “, 4.3-д заасан мөнгөн тусламж” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.8 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт:

“6.1.3. Тухайн сум, хороонд оршин суугааг нотолсон сум, хорооны Засаг даргын тодорхойлолт.

~~/6.1.3. энэ хулийн 5 дугаар зүйлд заасан нөхцөл хангаж байгааг нотолсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан /баг, хорооны Засаг дарга, сум, багийн болон орхийн эмч, сургууль/-ны тодорхойлолт;/~~

2/6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“6.8. Сумын Засаг дарга, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 6.6, 6.7-д заасан баримт бичгийг үндэслэн тэтгэмж олгох, мөнгөн тусламж үзүүлэх тухай захирамж, тушаал гаргана.”

~~6.8. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 6.6, 6.7-д заасан баримт бичиг болон нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, эсхүл нийгмийн ажилтны саналыг үндэслэн тэтгэмж олгох буюу тусламж үзүүлэх тухай захирамж гаргана.~~

**4 дүгээр зүйл.** Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 11 сарын 30 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1. Нийгмийн даатгалын сан тус бүрийн жилийн орлого, зарлагын төсвийг Улсын Их хурал батална.”

~~1. Нийгмийн даатгалын сан тус бүрийн жилийн орлого, зарлагын төсвийг нийгмийн даатгалын орон нутгийн байгууллагын саналыг харгалзан нийгмийн даатгалын төв байгууллага боловсруулах бөгөөд уг төсвийг нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл батална.~~

2/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө:

Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/
Тэтгэврийн даатгал	7.0	7.0
Тэтгэмжийн даатгал	0.5	0.5
Эрүүл мэндийн даатгал	2.0	2.0
Ажилгүйдлийн даатгал	0.5	0.5
Шимтгэлийн дүн	10.0	10.0

3/15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 3 хүртэл хувиар ялгавартай тогтоох бөгөөд ялгавартайгаар шимтгэл төлөх ажил олгогчийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Засгийн газар тогтооно.”

~~/5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байдлаас нь хамааралтайгаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр ялгавартай төлөх ажил олгогчийн жагсаалтыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална./~~

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 2 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 43

#### ХҮҮХЭД БҮРТ МӨНГӨ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 8.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдийн ирээдүйд хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хүүхэд бүрт олгох мөнгийг тэтгэмжийн дэвтэр болон эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр тухайн хүүхдийн нэр дээр нээсэн банкин дахь мөнгөн хадгаламжийн дансаар дамжуулан улирал бүр хуваарилан олгож байхаар тогтоосугай.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 4.1-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг сар бүр авч байгаа хүүхдээс нэмэлт бичиг баримт шаардахгүйгээр нэрсийн жагсаалтыг үндэслэн тухайн хүүхдийн нэр дээр нээлгэсэн мөнгөн хадгаламжийн дансанд мөнгийг нь шилжүүлж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл нарт даалгасугай.

3. Мөнгө авах хүсэлтээ шинээр гаргасан болон 18 нас хүрсэн хүүхдийн мөнгийг тухайн улирлын хуанлийн өдрөөр тооцон олгож байсугай.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

Монгол Улсын  
Шадар сайд

Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн сайд

М.ЭНХБОЛД

М.ЭНХСАЙХАН

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР  
БОДОХ ЦАЛИНГИЙН ИТГЭЛЦҮҮР БАТЛАХ ТУХАЙ**

**2007 оны 5 дугаар сарын 2 -ны өдөр**

**Улаанбаатар хот**

**Дугаар 109**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт даалгасугай:

а/ Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийг энэ тогтоолын хавсралтаар батлагдсан цалингийн итгэлцүүрээр шинэчлэн тогтоож 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс тооцон олгох;

б/ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг хэрэглэсэн боловч тэтгэвэр нь нэмэгдээгүй иргэдийн тэтгэврийг одоо авч байгаа хэмжээнээс нь бууруулахгүй байх зарчим баримтлах.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн ангилал, индексийг батлах тухай” Засгийн газрын 2006 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 207 дугаар тогтоолыг 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

Сангийн сайд

Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн сайд

М.ЭНХБОЛД

Н.БАЯРТСАЙХАН

Д.ДЭМБЭРЭЛ

Засгийн газрын 2007 оны 109 дүгээр  
тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР БОДОХ  
ЦАЛИНГИЙН ИТГЭЛЦҮҮР

№	Он	Итгэлцүүр
1.	1990 ба түүнээс өмнөх онууд	200
2.	1991	100
3.	1992	50
4.	1993	24
5.	1994	12.60
6.	1995	10.06
7.	1996	4.60
8.	1997	3.83
9.	1998	3.54
10.	1999	3.22
11.	2000	2.06
12.	2001	1.74
13.	2002	1.51
14.	2003	1.51
15.	2004	1.28
16.	2005	1.20
17.	2006	1.00
18.	2007	1.00

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

Төрийн захиргааны болон төрийн  
үйлчилгээний албан тушаалын ангилал,  
зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 7.10, 9.2-т заасныг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг 1 дүгээр хавсралтын, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 2 дугаар хавсралтын, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 3 дугаар хавсралтын, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 4 дүгээр хавсралтын, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 5 дугаар хавсралтын, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 6 дугаар хавсралтын, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ангилал, зэрэглэлийг 7 дугаар хавсралтын ёсоор тус тус баталж 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 236 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

С.БАЯР

Сангийн сайд

Ч.УЛААН

Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн сайд

Д.ДЭМБЭРЭЛ

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах төрийн захиргааны албан тушаал, тэдгээртэй адилтгах албан тушаал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэл	Төрийн захиргааны албан тушаалын бүлэг, нэр	
				Төрийн захиргааны байгууллагын	Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал
А	Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах төрийн захиргааны албан тушаал, тэдгээртэй адилтгах албан тушаал	3	4	5
ТЭРҮҮН ТҮШМЭЛ	Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах төрийн захиргааны албан тушаалын товч тодорхойлолт	ТЗ-14	1. Яамны Төрийн нарийн бичгийн дарга	
		Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг боловсруулах хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнг төсвийн Ерөнхийлөн захиргаачийн өмнө хариуцна. Байгууллагын төсөв болон төрийн тусгай сангийн ашиглалтын талаар хариуцлага хүлээнэ.	ТЗ-13	1. Засгийн газрын агентлагийн дарга	1. Нийслэлийн Засаг даргын орлогч 2. Улаанбаатар хотын срөнхий менежер 3. Чөлөөт бүсийн захирагч
ЭРХЭЛСЭН ТҮШМЭЛ	Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах төрийн захиргааны албан тушаалын товч тодорхойлолт	ТЗ-12	1. Яамны газрын дарга 2. Засгийн газрын агентлагийн дэд дарга 3. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын дарга	1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга 2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга 3. Аймгийн Засаг даргын орлогч 4. Чөлөөт бүсийн срөнхий менежер
		Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлого боловсруулах хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын бүтцийн нэгжийг удирдах, бодлогын тодорхой чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж ажил гүйцэтгэл, үр дүнг тэргүүн түшмэлийн өмнө хариуцна.	ТЗ-11	1. Яамны газрын орлогч дарга	1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга 2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Үргэлжлэл

А	I	2	3	4	5
	<p>Яамны тасгийн дарга, ахлах мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах албан тушаал</p>		<p>Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд мэргэжил, мэргэшлийн талаар тэргүүлэх үүрэг хүлээж ажлын гүйцэтгэл, үр дүнг эрхэлсэн түшмэлийн өмнө хариуцна.</p>	<p>1. Яамны хэлтсийн дарга 2. Засгийн газрын агентлагийн газрын дарга 3. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын дэд дарга</p>	<p>1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга 2. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны хэлтсийн дарга 3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хэлтсийн дарга 4. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга 5. Чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны болон газрын дарга 6. Бүсийн зөвлөлийн нарийн бичгийн дарга</p>
ЛАХ ТҮШ МЭЛ			<p>ТЗ-9</p>		
			<p>ТЗ-8</p>		

Үргэлжлэл

Үргэлжлэл

<p>А</p> <p>ДЭСТҮШМЭЛ</p>	<p>1</p>	<p>2</p>	<p>3</p>	<p>4</p>	<p>5</p>
<p>ТЗ-5</p>	<p>1. Яамны Төрийн нарийн бичгийн даргын туслах 2. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын мэрэжжилтэн</p>	<p>ТЗ-4</p>	<p>1. Яамны Төрийн нарийн бичгийн даргын туслах 2. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын мэрэжжилтэн</p>	<p>1. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний нутгийн захиргааны байгууллагын мэрэжжилтэн 2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан 3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэрэжжилтэн 4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний нутгийн захиргааны байгууллагын мэрэжжилтэн 5. Улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн ажлын албаны мэрэжжилтэн 6. Аймгийн зэрэглэлтэй хотын захирагчийн ажлын албаны ахлах мэрэжжилтэн 7. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын ахлах мэрэжжилтэн 8. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн ахлах мэрэжжилтэн 9. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны мэрэжжилтэн</p>	<p>1. Аймгийн зэрэглэлтэй хотын захирагчийн ажлын албаны мэрэжжилтэн 2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан 3. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэрэжжилтэн 4. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн мэрэжжилтэн</p>
<p>ТЗ-3</p>	<p>Бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхүйц мэдээллийг сурвалжлан судалж, задлан шинжилгээ хийж гүйцэтгэсэн ажлын чанарын талаар харууцлага хүлээнэ. Нийтлэг үйлчилгээний ажилтан нарын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг хүлээнэ.</p>	<p>ТЗ-3</p>	<p>Сумын Засаг даргын Тамгын газрын мэрэжжилтэн, тэргээртэй адилтгах албан тушаал</p>	<p>1. Сумын Засаг даргын Тамгын газрын мэрэжжилтэн 2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан 3. Сумын газрын дасмал 4. Хорооны нийгмийн ажилтан 5. Хорооны бүртгэл мэдээлэл, зохион байгуулалтын асуудал хариуцсан ажилтан 6. Сумын нийгмийн ажилтан 1. Байгаль хамгаалагч</p>	<p>1. Сумын Засаг даргын Тамгын газрын мэрэжжилтэн 2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан 3. Сумын газрын дасмал 4. Хорооны нийгмийн ажилтан 5. Хорооны бүртгэл мэдээлэл, зохион байгуулалтын асуудал хариуцсан ажилтан 6. Сумын нийгмийн ажилтан 1. Байгаль хамгаалагч</p>
<p>ТЗ-1</p>	<p>1. Бөхийн нийгмийн ажилтан, зохион байгуулагч</p>	<p>ТЗ-1</p>	<p>1. Бөхийн нийгмийн ажилтан, зохион байгуулагч</p>	<p>1. Бөхийн нийгмийн ажилтан, зохион байгуулагч</p>	<p>1. Бөхийн нийгмийн ажилтан, зохион байгуулагч</p>

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Зэрэглэл	Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаал
	1		3	4
1	Удирдах албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаал	ТҮШУ-7	1. Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч
2			ТҮШУ-6	1. Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга
3			ТҮШУ-5	1. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал; 2. Шинжлэх ухааны академийн орлогч дарга
4			ТҮШУ-4	1. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга 2. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн сектор, лабораторийн эрхлэгч 3. Шинжлэх ухааны академийн хэлтсийн дарга
5	Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нарийн мэргэжил, авъяас, ур чадвар, туршилага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээрээ бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮШУ-3	1. Эрдэм шинжилгээний ажилтан; 2. Зохион бүтээгч инженер
6			ТҮШУ-2	1. Шинжлэх ухааны академийн мэргэжилтэн; 2. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн инженер; 3. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан
7	Техникийн гүйцэтгэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилтыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮШУ-1	1. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан /лаборант, техникч, механикч/

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр  
тогтоолын 3 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ АЖИЛ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН  
ТОГТООЛЫН 3 ДУГААР ХАВСРАЛТ

Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Зэрэглэл	Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаал	Удирдах албан тушаалтай дүйцүүлж мэргэжлийн албан тушаал
1		3	4	5
Удирдах албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагын удирдаж, эрх хэмжээнийг хэрэгэнд шийдвэр гаргадаг албан тушаал	ТҮМБ-9	1. Их сургуулийн захирал	
		ТҮМБ-8	1. Дээд сургуулийн захирал 2. Их сургуулийн дэд захирал	1. Магистр, докторын сургалтын профессор
		ТҮМБ-7	1. Дээд сургуулийн дэд захирал 2. Коллежийн захирал 3. Их сургуулийн факультет /сургууль/-ийн захирал/декан/ 4. Их, дээд сургуулийн сургалтын албаны дарга	1. Магистр, докторын сургалтын дэд профессор
		ТҮМБ-6	1. Их, дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч 2. Коллежийн сургалтын албаны дарга 3. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн захирал	1. Магистр, докторын сургалтын ахлах багш 2. Бакалаврын сургалтын профессо
		ТҮМБ-5	1. Коллежийн тэнхимийн эрхлэгч 2. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн дэд захирал	1. Магистр, докторын сургалтын 2. Бакалаврын сургалтын дэд проф
		ТҮМБ-4	1. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын менежер	1. Бакалаврын сургалтын ахлах багш
Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нэрийн мэргэжил, авъяас, ур чадвар, туршлага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээр бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮМБ-3	1. Бакалаврын сургалтын багш	1. Бакалаврын сургалт-үйлдвэрлэлийн төвийн багш
		ТҮМБ-2	1. Бакалаврын сургалтын дадлагажигч багш	
		ТҮМБ-1	1. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн дадлагажигч багш	

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр  
тогтоолын 4 дүгээр хавсралт

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН  
БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Зэрэглэл	Зээмиүүлэх сургалтын байгууллагуудын төрийн үйлчилгээний албан тушаал
	1	2	3	4
1	Удирдах албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх хэмжээний хээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаал	ТҮБД-8	1. Ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн захирал
2			ТҮБД-7	1. Ерөнхий боловсролын сургуулийн захирал 2. Ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн сургалтын ерөнхий менежер
3			ТҮБД-6	1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер 2. Цэцэрлэг, яслийн эрхлэгч
4	Мэргэжлийн албан хаагч	Тодорхой наррийн мэргэжил, авъяас, ур чадвар, туршилага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээр бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮБД-5	1. Ерөнхий боловсролын тусгай сургуулийн арга зүйч
5			ТҮБД-4	1. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан 2. Ерөнхий боловсролын сургуулийн багш 3. Цэцэрлэг, яслийн арга зүйч 4. Цэцэрлэг, яслийн багш
6			ТҮБД-3	1. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багш 2. Ерөнхий боловсролын тусгай сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан
7			ТҮБД-2	1. Хичээлийн зохицуулагч
8	Техникийн гүйцэтгэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилтыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮБД-1	1. Цэцэрлэг, яслийн туслах багш

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр  
тогтоолын 5 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗӨРӨГЛӨЛ

Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Зэрэглэл	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал	Удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших мэргэжлийн албан тушаал
Удирдах албан хаагч	2 Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаал	3 ТҮЭМ-9	4 1. Улсын клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн дарга, захирал 2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга 3. Улсын хэмжээний рашаан сувиллын дарга	5 Удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших мэргэжлийн албан тушаал
Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нарийн мэргэжил, авьяас, үр чадвар, туршлага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээрээ бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮЭМ-8	1. Улсын клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн орлогч дарга, дэд захирал 2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн орлогч дарга 3. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн дарга	1. Улсын клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн зөвлөх эмч 2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн зөвлөх эмч
		ТҮЭМ-7	1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн орлогч дарга, тэдгээртэй адилтгах байгууллагын дарга 2. Аймагийн зэрэглэлтэй хотын нэгдсэн эмнэлгийн дарга	
		ТҮЭМ-6	1. Сум, тосгон, сум дундын эмнэлгийн дарга 2. Эмнэлгийн албаны дарга буюу эмнэлгийн чанарын болон хүний нөөцийн менежер 3. Аймагийн зэрэглэлтэй хотын нэгдсэн эмнэлгийн орлогч дарга	
Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нарийн мэргэжил, авьяас, үр чадвар, туршлага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээрээ бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮЭМ-5	1. Улсын клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн эмнэлгийн орлогч дарга 2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн их эмч, эм зүйч, эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан	1. Улсын клиникийн болон төрөлжсөн эмнэлгийн зөвлөх эмч 2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн их эмч, эм зүйч, эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан
		ТҮЭМ-4	1. Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн нэгдэл, аймгийн зэрэглэлтэй хотын нэгдсэн эмнэлэг, тэдгээртэй адилтгах байгууллагын их эмч, эм зүйч, эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан	
		ТҮЭМ-3	1. Дадиагажигч эмч 2. Сум, тосгон, сум дундын эмнэлгийн их эмч	
		ТҮЭМ-2	1. Сувиллагч 4. Эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн	
Техникийн гүйцэтгэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилгыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, үр чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮЭМ-1	1. Ариутгагч (дэскамерчин, автоклавчин) 2. Эмгэг судлаач эмчийн туслах	

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр  
ТОГТООЛЫН 6 дугаар хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН  
ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын төвч тодорхойлолт	Зэрэглэл	Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал
1	Удирдах албан хаагч	1	3	4
2		Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагуудад аж, эрх хэмжээнийгээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаал	ТУСУ-11	1. Эрдмийн театр, чуулгын ерөнхий захирал 2. Үндэсний номын сангийн захирал 3. Үндэсний музейн захирал
3			ТУСУ-10	1. Эрдмийн театр, чуулгын дэд захирал 2. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын дарга, захирал 3. Эрдмийн театр, чуулгын уран сайхны удирдагч 4. Үндэсний номын сангийн дэд захирал 5. Үндэсний музейн дэд захирал
4			ТУСУ-9	1. Орон нутаг дахь мэргэжлийн урлагийн байгууллагын дарга, захирал 2. Эрдмийн театр, чуулгын ерөнхий удирдагч, ерөнхий найруулагч, ерөнхий хормейстер, ерөнхий балетмейстер, ерөнхий зураач 3. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын уран сайхны удирдагч 4. Улаанбаатар хот дахь улсын чанартай музейн захирал 5. Соёлын өвийн төвийн захирал 6. Хуухдийн номын ордны захирал 7. Улаанбаатар хот дахь төв номын сангийн захирал
5			ТУСУ-8	1. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын ерөнхий найруулагч, ерөнхий удирдагч, ерөнхий балетмейстер, ерөнхий хормейстер, ерөнхий зураач 2. Эрдмийн театр, чуулгын удирдагч, багш, найруулагч, балетмейстер, хормейстер, зураач 3. Орон нутаг дахь мэргэжлийн урлагийн байгууллагын уран сайхны удирдагч 4. Орон нутаг дахь төв номын сангийн захирал 5. Улаанбаатар хот дахь улсын чанартай музейн дэд захирал 6. Орон нутаг дахь төв музейн захирал 7. Улаанбаатар хот дахь төв номын сангийн дэд захирал 8. Үндэсний номын сангийн нэгжийн дарга 9. Үндэсний музейн нэгжийн дарга
			ТУСУ-7	1. Орон нутаг дахь мэргэжлийн урлагийн байгууллагын ерөнхий удирдагч, ерөнхий найруулагч, ерөнхий балетмейстер, ерөнхий хормейстер, ерөнхий зураач, багш 2. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын удирдагч, найруулагч, балетмейстер, хормейстер 3. Улаанбаатар хот дахь улсын чанартай музей, соёлын өвийн төвийн сан хөмрөгийн эрхлэгч, лабораторийн эрхлэгч, бүртгэл мэдээллийн санч 4. Улаанбаатар хот дахь дүүргийн номын сангийн эрхлэгч 5. Орон нутаг дахь төв номын сангийн нэгжийн дарга 6. Хуухдийн номын ордны нэгжийн дарга

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр  
ТОГТООЛЫН 6 дугаар хавсралтын үргэлжлэл

САЛБАРЫН БОДЛОГО, ШИЙДВЭР

6	Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нарийн мэргэжил, авьяас, ур чадвар, туршилага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээрээ бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮСУ-6	<ol style="list-style-type: none"> <li>1. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын хөгжимчин, жүжигчин, дуучин, бүжигчин, концертмейстер, дасгалжуулагч, ээрлийн инженер, цахилгааны инженер, зураач</li> <li>2. Үндэсний номын сангийн арга зүйч, ном зүйч, эрдэм шинжилгээний ажилтан, ахлах номын санч, компьютерийн инженер, программист</li> <li>3. Улаанбаатар хот дахь улсын чанартай музей, соёлын өвийн төвийн арга зүйч, эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч, сэргээн засварлагч</li> <li>4. Орон нутгийн музейн бүртгэл мэдээллийн санч, сан хөмрөгч</li> <li>5. Сумын соёлын төвийн эрхлэгч</li> </ol>
7			ТҮСУ-5	<ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагын хөгжимчин, жүжигчин, дуучин, туслах найруулагч, концертмейстер, дасгалжуулагч</li> <li>2. Музей, соёлын өвийн төвийн куратор, сүлжээний инженер, тайлбарлагч, зураач-дизайнер, боловсролын ажилтан, чихмэлийн мастер, арга зүйч, эрдэм шинжилгээний ажилтан</li> <li>3. Номын сангийн ном зүйч, арга зүйч, ахлах номын санч, ном бүрдүүлэгч, бүртгэл мэдээллийн номын санч, фондогч, ном ангиллагч, ном данслагч, ховор гар бичмэлийн сэргээн засварлагч</li> <li>4. Гэрлийн найруулагч, дууны найруулагч</li> <li>5. Сумын номын сангийн эрхлэгч</li> </ol>
8			ТҮСУ-4	<ol style="list-style-type: none"> <li>1. Төвтр, чуулгын утга зохиолын ажилтан, нот бичигч, ээрийн оператор, дууны оператор, хөгжим засварчин, туслах зураач, оёдлын мастер</li> <li>2. Сумын соёлын төвийн дуу, хөгжмийн багш, бүжгийн багш, орон нутаг судлах тэнхимийн ажилтан, кино механикч-техникчийн ажилтан, номын санч-мэдээллийн ажилтан</li> <li>3. Музейн чихмэлчин, үйлчилгээний зохион байгуулагч</li> <li>4. Номын сангийн уншлага үйлчилгээний номын санч</li> <li>5. Төвтр, чуулгын фондын эрхлэгч</li> <li>6. Тайзны машинист</li> <li>7. Номын сангийн ном сэлбэн засагч</li> </ol>
9	Техникийн гүйцэтгэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилтыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮСУ-3	<ol style="list-style-type: none"> <li>1. Нуур хувиргагч</li> <li>2. Оёдолчин, гуталчин, парикчин</li> </ol>
10			ТҮСУ-2	<ol style="list-style-type: none"> <li>1. Хувцасны эрхлэгч</li> <li>2. Тайзны жижиг хэрэгсэлийн эрхлэгч</li> <li>3. Тасалбар түгээгүүрийн хясаачин</li> <li>4. Музейн үзэмэр хянагч</li> <li>5. Гэрэлтүүлэгч</li> <li>6. Урын сангийн ажилтан</li> </ol>
11			ТҮСУ-1	<ol style="list-style-type: none"> <li>1. Тайз засагч</li> <li>2. Ном ариутгаагч</li> <li>3. Билет шалгагч</li> </ol>

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр  
тогтоолын 7 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Зэрэглэл	Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал
3	Үдирдах албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх хэмжээнийгээ хүрээнд ишийдвэр гаргадаг албан тушаал	3 ТҮ-12	1. Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын дарга 2. Үндэсний төв архивын захирал
4			ТҮ-11	1. Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын нэгжийн дарга 2. Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын дарга
5			ТҮ-10	1. Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын нэгжийн дарга 2. Улсын мэрэгжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн чанарын менежер 3. Улсын биеийн тамир, спорт, соёл, урлаг, амралт, хүүхэд, залуучуудын зэрэг төсвийн байгууллагын дарга
6			ТҮ-9	1. Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ерөнхий инженер 2. Улсын мэрэгжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн техникийн менежер 3. Үндэсний төв архивын нэгжийн дарга 4. Орон нутгийн биеийн тамир, спорт, соёл, урлаг, амралт, хүүхэд, залуучуудын зэрэг төсвийн байгууллагын дарга
7	Мэргэжлийн албан хаагч	Тоорхой нарийн мэрэгжил, авьяас, ур чадвар, туршлага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэрэгжлээр бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮ-8	1. Ерөнхий нягтлан бодогч 2. Эдийн засагч 3. Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ахлах мэрэгжилтэн, инженер 4. Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ерөнхий инженер, ерөнхий технологич 5. Улсын мэрэгжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн ахлах шинжээч 6. Үндэсний төв архивын эрэмб шинжилгээний ахлах ажилтан, ахлах зааварлагч-арга зүйч, ахлах архивч, 7. Биеийн тамир, спортын байгууллагын улсын ерөнхий дасгалжуулагч

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын  
7 дугаар хавсралтын үргэлжлэл

8			ТУ-7	<p>1. Маркетингийн албаны ажилтан, хүний нөөцийн ажилтан 2. Нягтлан бодогч, программист, сүлжээний инженер, хуулийн зөвлөх, архитекторч, технологич 3. Яамны эрхлэх асуудлын хурээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын мэргэжилтэн 4. Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хурээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ахлах техникч 5. Улсын мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн шинжээч 6. Биеийн тамир, спортын байгууллагын улсын дасгалжуулагч 7. Үндэсний төв архивын эрэм шинжилгээний ажилтан, зааварлагч-арга зүйч, судлаач-архивч, хадагалалт хамгаалалтын технологич, кино бүрс бичлэгийн инженер, зохион байгуулагч</p> <p>1. Нийгмийн ажилтан, их эмч, орчуулагч, инженер, биологич, химич, физикч 2. Яамны эрхлэх асуудлын хурээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын зохион байгуулагч 3. Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хурээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын мэргэжилтэн, техникч, газгенерааторч, ус цаг уур орчны ажиглагч 4. Үндэсний төв архивын микрофильмийн техникч, микрофильм, архивч-операторч, архивч-зах бэлтгэгч хөмрөгийн эрхлэгч, уншилагын танхимын эрхлэгч, архивч-операторч, архивч-зах бэлтгэгч 5. Биеийн тамир, спортын байгууллагын дасгалжуулагч 6. Биеийн тамир, спорт, соёл, урлаг, амралт, хүүхэд, залуучуудын зэрэг төсвийн байгууллагын багш, арга зүйч, мэргэжилтэн</p>
9			ТУ-6	<p>1. Механикч, техникч, архив-бичиг хэргийн эрхлэгч, бага эмч 2. Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хурээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын зохион байгуулагч 3. Улсын мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн лаборант 4. Үндэсний төв архивын дөвтэрлэгч, хэвлэгч, галын багон хамгаалалтын системийн техникч, баримт ариутгагч, лаборант, соёл, урлаг, амралт, хүүхэд, залуучуудын зэрэг төсвийн байгууллагын зохион байгуулагч 5. Биеийн тамир, спорт, соёл, урлаг, амралт, хүүхэд, залуучуудын зэрэг төсвийн байгууллагын автоклавчин 1. Нарийн бичгийн дарга, диспетчер, няраг, сувиллагч 2. Эрдем шинжилгээ, боловсролын байгууллагын номын санч 1. Жолооч, цахилгаанчин, слесарь, токарчин, зураач, гэрэл зурагчин, харуулын ахлагч, кабельчин, лаборант, холбоочин 2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны болон цэцэрлэг, яслийн тосгооч Хуулагч, олирчуулагч, тоо бүртгэгч, данс хөтлөгч, экспедиторч, операторч, муржаан, бичээч, оёдолчин, усчин, архивч, номын санч, ишл үлээгч, тасалбар тгээгчийн кассчин, өртөөч, уурын зуухны галч, тогооч, ангчин, хор өгөөш найруулагч, ариутгах төхөөрөмжийн ашигтатчин, асрагч</p>
10			ТУ-5	<p>1. Механикч, техникч, архив-бичиг хэргийн эрхлэгч, бага эмч 2. Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хурээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын зохион байгуулагч</p>
11	Техникийн гүйцэтгэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилтыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТУ-4	<p>1. Улсын мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн автоклавчин 2. Нарийн бичгийн дарга, диспетчер, няраг, сувиллагч 3. Эрдем шинжилгээ, боловсролын байгууллагын номын санч</p>
12			ТУ-3	<p>1. Жолооч, цахилгаанчин, слесарь, токарчин, зураач, гэрэл зурагчин, харуулын ахлагч, кабельчин, лаборант, холбоочин</p>
13			ТУ-2	<p>2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны болон цэцэрлэг, яслийн тосгооч Хуулагч, олирчуулагч, тоо бүртгэгч, данс хөтлөгч, экспедиторч, операторч, муржаан, бичээч, оёдолчин, усчин, архивч, номын санч, ишл үлээгч, тасалбар тгээгчийн кассчин, өртөөч, уурын зуухны галч, тогооч, ангчин, хор өгөөш найруулагч, ариутгах төхөөрөмжийн ашигтатчин, асрагч</p>
14	Бага туш аалын албан хаагч	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай мэргэжил, боловсрол үл шаардах үйлчилгээний ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТУ-1	<p>Жижүүр, хаагагч, манач, сахиул, харуул, зөөгч, түгээгч, үйлчлэгч, цэвэрлэгч, зарлага, ердийн хөсөгчин /морин тээгэгчин/, хувцас өлгөгч, галч, гал тогсооны туслагч, билет шалгагч, ачигч, угаагч, индүүрэгч, хатаагч, туслах малчин, амьтан маллагч, хувцас хадгалагч, ариутгагч, шатаах зуухны ажигчин, лифтчин, хөдгийн моторчин</p>

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 351

Улаанбаатар  
хот

Төрийн албан хаагчийн албан  
тушаалын цалингийн сүлжээ, доод  
жишгийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.4.3, 28.6-г үндэслэн Монгол  
Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралтын, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралтын, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралтын, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хавсралтын, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 5 дугаар хавсралтын, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 6 дугаар хавсралтын, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 7 дугаар хавсралтын, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 8 дугаар хавсралтын, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод жишгийг 9 дүгээр хавсралтын ёсоор тус тус шинэчлэн баталж, 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Төрийн албан хаагчийн цалин хөлсний асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх зорилгоор төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэл, цалин хөлсний бүтэц, нийгмийн баталгааны цэгцтэй бодлогыг

тодорхойлж Төрийн албаны тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжийг судалсны үндсэн дээр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж 2008 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 237 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАЯР

Сангийн сайд


Ч.УЛААН

Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн сайд


Д.ДЭМБЭРЭЛ

Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт


Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт




Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт



Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт




Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт



Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт



Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт



Засгийн газрын 2007 оны 351 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 350

Улаанбаатар  
хот

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг  
шинэчлэн тогтоох тухай

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 642 төгрөг 85 мөнгө буюу сард 108000 (нэг зуун найман мянган) төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 240 дүгээр тогтоолыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

С.БАЯР

Сангийн сайд

Ч.УЛААН

Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн сайд

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 355

Улаанбаатар  
хот

### Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 81000 төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 54000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлэн 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцон олгох арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 241 дүгээр тогтоолыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

С.БАЯР

Сангийн сайд

Ч.УЛААН

Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн сайд

Д.ДЭМБЭРЭЛ

## Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбары 2007 оны үйл ажиллагааны үр дүнгээс

Өнгөрсөн 2007 он шинэ ажлын байр бий болгож хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төрийн албан хаагчдын цалин хөлс, айл өрхийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн эмзэг хэсэгт үзүүлэх дэмжлэг туслалцааг сайжруулах талаар мэдэгдэхүйц амжилт бүтээл гарсан жил болов.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн багц 2007 онд 438.4 тэрбум төгрөгөөр батлагдав. Үүнээс 249.2 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын сангаар олгох тэтгэвэр тэтгэмжинд, 120.8 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангаар дамжуулан хүн ам, гэр бүлд тэтгэвэр тэтгэмж, тусламж үйлчилгээний хэлбэрээр, 11,0 тэрбум төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд тус тус зарцуулав.

Нийгмийн хамгааллын салбарын ажиллагчид 2007 онд онд 17.5 мянган ажил олгогч, 2152.9 мянган даатгуулагч иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээ, 1480,9 мянган иргэнд нийгмийн халамжийн болон хүн ам, гэр бүлийн дэмжлэг туслалцаа, 224.3 мянган иргэн, 188 аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлснээр үйлчлүүлэгчдийн тоо өнгөрсөн оноос 11.8 хувиар нэмэгдэв.

**Ажилгүйдлийн түвшин буурав.** Засгийн газраас 2007 оныг “Их бүтээн байгуулалт - Шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил” болгон зарлаж, дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлснээр



аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээтэй хослон ажлын байр шинээр бий болоход мэдэгдэхүйц нөлөө үзүүлэв. 2007

онд 81172 ажлын байр шинээр бий болж, ажилгүйдлийн түвшин өмнөх онтой харьцуулахад 0.2 пунктээр, 2004 онтой харьцуулахад 0.6 пунктээр тус тус буурав.

**Жижиг зээл үр дүнгээ өгөв.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 3129 албан бус хөдөлмөр эрхлэгч, 1852 ажилгүй иргэн, 757 малчин, 188 аж ахуйн нэгж байгууллагад 7 тэрбум 832.3 сая төгрөгийн зээл олгосны үр дүнд 16658 хүн ажлын байраар хангагдав. Үүний тал шахам хувь нь нэг сая хүртэлх төгрөгийн зээлээр бий болов. Тухайлбал, нэг сая хүртэл төгрөгийн зээл авсан 1846 албан бус хөдөлмөр эрхлэгч, 1433 ажилгүй иргэн, 44 аж ахуйн нэгж, 578 малчин нийт дүнгээрээ 2 тэрбум 889.6 сая төгрөгөөр 7608 хүн ажлын байр бий болгожээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 10 тэрбум 871.4 сая төгрөг зарцуулав.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээтэй холбоотой зарим үзүүлэлт

№	Үзүүлэлт	2004	2005	2006	2007
1	Бүртгэлтэй ажилгүй иргэн	35554	32928	32928	30796
2	Ажилгүйдлийн түвшин	3.7	3.3	3.2	3.0
3	Ажлын байрны захиалгын тоо	39023	40698	47281	61344
4	Ажилд зуучлан оруулсан хүний тоо	38445	41989	43092	53575
5	Мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүний тоо	22265	19493	22040	22766
6	Нийтийг хамарсан ажилд хамрагдсан хүний тоо	18711	17877	17317	17132
7	Шинээр бий болсон ажлын байрны тоо	35000	53105	53036	81172
8	Хөдөлмөр эрхлэлтийг жижиг зээлээр дэмжих арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө /тэрбум төгрөг/	2.9	1.9	3.5	7.8
9	Жижиг зээлээр бий болсон ажлын байрны тоо	3974	2180	7159	16658
10	Гадаадын иргэдэд үзүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ	23709	25433	37504	46985

**Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 90000, төрийн албан хаагчдын дундаж цалин 250000-д хүрэв.** Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээг тайлант оны эхнээс болон 10 дугаар сарын нэгнээс хоёр удаа авч хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээний үр дүнд хөдөлмөрийн хөлсний доод 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс 69.0 мянган төгрөг, 10 дугаар сарын 1-нээс 90.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин оны эхнээс 156,0 мянган төгрөг, 10 дугаар сарын 1-нээс 250,0 мянган төгрөгт хүрэв. Мөн 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэг цагт 642 төгрөг 85 мөнгө буюу сард 108000 /нэг



зуун найман мянган/ төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин 300,0 мянган төгрөгт хүргэх шийдвэрийг гарган хэрэгжүүлж байна. Энэхүү арга хэмжээнд 129773 төрийн албан хаагч болон 18712 гэрээт ажилчин хамрагдана.




**Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 218.1 тэрбумд хүрэв.** Өнгөрсөн 2007 онд 17.5 мянган ажил олгогч, 2152.9 мянган даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдаж шимтгэлийн орлого 218.1 тэрбум төгрөгт хүрэв. Энэ нь 2000 оныхоос 3.6 дахин, 2005 оныхоос 1.7 дахин, 2006 оныхоос 60.4 тэрбум төгрөгөөр илүү байна.

**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээ нэмэгдэв.** 2007 онд авч хэрэгжүүлсэн тэтгэвэр нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүү арилгах арга хэмжээний үр дүнд нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн хэмжээ 67500, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 45000, дундаж тэтгэвэр 80200 төгрөгт тус тус хүрэв. Энэ арга хэмжээнд 32.9 тэрбум төгрөг зарцуулж, давхардсан тоогоор 810.5 мянган хүн хамрагдав.


Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө, 2007 оны байдлаар

№	Тогтоолын шийдвэр	Төрөл	Доод тэтгэвэр		Бусад тэтгэвэр		Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /тэрбум төг/
			Хүний тоо	Тэтгэврийн доод хэмжээ	Хүний тоо	Тэтгэврийн хэмжээ /дундаж/	
1	Засгийн газрын 2007 оны 15 дугаар тогтоол (2007.01.01-2007.07.01)	Бүрэн тэтгэвэр	114000	51750	160500	58300	9.9
		Хувь тэнцүүлсэн тэтгэвэр	12900	34500		28900	
		Нийт	126900	-		53900	
2	Засгийн газрын 2007 оны 109 дугаар тогтоол (2007.07.01-2007.10.01)	Бүрэн тэтгэвэр	-	-	60200	69200	6.1
		Хувь тэнцүүлсэн тэтгэвэр	-	-		36500	
		Нийт	-	-		64300	
3	Засгийн газрын 2007 оны 110 дугаар тогтоол (2007.07.01-2007.10.01)	Бүрэн тэтгэвэр	133000	56250	-	-	3.3
		Хувь тэнцүүлсэн тэтгэвэр	38900	37500	-	-	0.7
		Нийт	171900	-	-	-	4.0
4	Засгийн газрын 2007 оны 241 дугаар тогтоол (2007.10.01-2007.12.31)	Бүрэн тэтгэвэр	134200	67500	117700	104400	4.6
		Хувь тэнцүүлсэн тэтгэвэр	39100	45000		62400	0.9
		Нийт	173300	-		80200	3.4

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн доод хэмжээ, 2007 онд



Нийгмийн даатгалын сангаас олгосон бусад тэтгэврийн хэмжээ, 2007 онд



ЗГ-аас 2008 оны 1-р сарын 1-нээс НДС-гаас олгох тэтгэврийн хэмжээг 20,0 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

**131.7 мянган “Алдарт эх” мөнгөн тусламж авав.** “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль”-д өөрчлөлт орсноор “Алдарт эх”-ийн 1, 2 дугаар зэргийн одонтой эхчүүд нас харгалзахгүйгээр мөнгөн тусламж олгох арга хэмжээнд хамрагдав. “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонтой 39272 эх 100.0 мянга, хоёрдугаар зэргийн одонтой 92424 эх 50.0 мянган төгрөгийн тэтгэмж авлаа.

**77.5 мянган жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эх тэтгэмж авав.** “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль”-ийн 8.1-д заасны дагуу эх жирэмсний 5 сартайгаас эхлэн нэг жилийн хугацаанд сар бүр 20.0 мянган төгрөг авч байна. Энэ арга хэмжээнд 2007 онд 77.5 мянган эх хамрагдаж 12.7 тэрбум төгрөг зарцуулав.

**59.5 мянган шинэ гэр бүл дэмжлэг авав.** Эх хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн дагуу гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлсэн боловч 2006 онд тусламжаа авч чадаагүй 24.5 мянган шинэ гэр бүл, 2007 онд гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн 35 мянган шинэ гэр бүл, нийт 59.5 мянган шинээр гэрлэсэн хос нэг удаагийн тусламжийн 500000 төгрөгөө авав.

**948.7 мянган хүүхэд Монгол улсыг хөгжүүлэх сангаас дэмжлэг хүртэв.** Эх, хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээний хүрээнд

0-18 хүртэлх насны бүх хүүхэд сар бүр 3000 төгрөгийн тэтгэмж, Монгол улсыг хөгжүүлэх сангаас улирал бүр 25000 жилдээ 100.0 мянган төгрөгийн дэмжлэг хүртэв. Эдгээр тэтгэмж, дэмжлэгийг бэлнээр болон банкны хадгаламжийн дансаар дамжуулан сар, улирал бүр олгох ажлыг саадгүй зохион байгуулж ирлээ.

**2007 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хүртэгсэд болон зарцуулсан хөрөнгийн талаарх тоон мэдээ:**

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 948713 хүүхдэд 33.2 тэрбум төгрөг,
- Шинээр төрсөн 57693 хүүхдэд 5 тэрбум 769.3 сая төгрөг,
- Шинээр гэр бүл болсон 59448 өрхөд 29 тэрбум 724.0 сая төгрөг,
- Алдар цолтой 6458 ахмадуудад 764.9 сая төгрөг,
- Алдарт эхийн одонтой 131696 эхчүүдэд 8 тэрбум 496.7 сая төгрөг,
- Жирэмсэн болон хөхүүл, нярай хүүхэдтэй 77455 эхчүүдэд 12.7 тэрбум төгрөг,
- Хүүхэд асарсаны тэтгэмж 22.3 мянган эхчүүдэд 1.5 тэрбум төгрөг,
- Ахмад настныг асарч буй 4326 иргэнд 579.0 сая төгрөг,
- ХБИ-ийг асарч буй 6278 иргэнд 924.0 сая төгрөг,
- Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжинд 376 иргэнд 68.9 сая төгрөгийг тус тус олгосон байна.

**Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлт, үйлчилгээнд хамруулав.** Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу 113073 ахмад настанд 2.6 тэрбум төгрөгийн, 21970 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж үйлчилгээг үзүүлэв.

**Нэг тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийв.** Улсын төсвийн эх үүсвэрээс нийгмийн хамгааллын үйлчилгээний байр, орчны тохижилт, ахмад настны сувилал, асрамжийн үйлчилгээг сайжруулах, нэн ядуу иргэдэд тусламжийн гэр олгоход зориулан нийт 1284.2 мянган төгрөг зарцуулав

## БАЙГАЛИЙН СЭРГЭЭГДЭХГҮЙ НӨӨЦИЙН ОРЛОГЫН ЗОХИСТОЙ МЕНЕЖМЕНТ - ТУСГАЙ САН

Байгалийн нөөц багатай орнуудын хувьд хөгжлийн эх үүсвэр бий болгох асуудал чухлаар тавигддаг бол байгалийн баялаг ихтэй орнуудад баялагаас олсон орлогоо хэрхэн ашиглах асуудал анхаарал татаж байна. Хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын аль алинд энэ асуудал нилээд тулгамдсан шинжтэй болж байгаа учраас олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, тухайлбал Дэлхийн банкнаас янз бүрийн бүс нутгийн улс орнуудад судалгаа хийж, семинар зохион байгуулж байна.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаанаас үзвэл нилээд олон орон байгалийн сэргээгдэхгүй нөөцийн орлогыг үр ашигтай ашиглах оролдого хийж байгаа ажээ. Тэдгээр оролдлогын нэг нь тусгай сан байгуулж менежмент хийх явдал юм. Гэхдээ хамгийн чухал нь санхүүгийн ерөнхий менежмент сайн байх явдал бөгөөд хэрвээ энэ чадавхи сул бол тусгай сан байгуулаад ч бэрхшээлийг даван туулж чадахгүй гэж Дэлхийн Банкны судлаачид дүгнэсэн байна. Байгалийн нөөц ашигласны орлогоо зохистой удирдаж байгаа орнуудын тоонд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Оросын Холбооны Улс, Саудийн Араб, Индонез, Австрали зэрэг улс багтаж байна.

Тусгай сан байгуулах нь дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Сэргээгдэшгүй нөөцийн орлого төсвийн хомсдлыг нөхөх хэлбэрээр үр ашиггүй зарцуулагдахаас сэргийлэх,
- Байгалийн баялгийн ашиглалтаас олсон гэнэтийн орлого хүн амд бэлэн мөнгөний хэлбэрээр очиж, инфляцийг хөөрөгдөх аюултай учир түүнээс сэргийлж, тусгай санд байршуулан хөрөнгийн зах зээл дээр, гэхдээ гадаад зах зээлд ашиглах,
- Улс орны тогтвортой хөгжлийн эх үүсвэрийг бүрдүүлэх, тухайлбал, нефтийн нөөц дуусах үед түүнээс шалтгаалан эдийн засаг хямрахгүй байхаар тооцож хөрөнгийн эх үүсвэр хуримтлуулсан байх,
- Эдийн засгийн гэнэтийн цохилтын хор уршгийг арилгах, төсвийн гэнэтийн хомсдолыг нөхөх нөөцтэй байх (ОХУ).

Байгалийн сэргээгдэхгүй нөөцийн орлогыг яагаад тусгай санд байршуулах ёстой юм бэ?, Ихэнхи орнууд, ялангуяа хөгжиж байгаа орнууд хөрөнгө мөнгөний дутагдалтай, төсвийн хомсдолтой, гадаадаас зээл авдаг шүү дээ гэсэн асуулт гарч болох юм.

Тэгвэл нефть, алт, зэс, нүүрс гэх мэт байгалийн баялаг ихтэй орнууд ихэнхдээ эдгээр баялгаа экспортлох хэлбэрээр орлого олж байна. Энэ нь тухайн улс орнуудыг байгалийн нөөцийн орлогоо хэт шүтэх хандлагад оруулж, эдийн засгийн бусад салбарын хөгжилд сөргөөр нөлөөлдөг байна. Нөгөө талаар энэхүү экспортын орлого дэлхийн зах зээлийн үнээс хамааран огцом хэлбэлзэх тохиолдолд орлогын илүүдэл буюу “эдийн засгийн халуурал”, эсвэл төсвийн хомсдол буюу эдийн засгийн хямрал үүсгэх үр дагавартай ажээ. Иймд эдийн засгийн хэлбэлзлээс ангид байх зорилгоор байгалийн нөөцийн орлогыг тусгай санд байршуулж, аль болохоор гадаад зах зээл дээр байршуулан зохистой ашиглах явдлыг чухалчилж байна.

Тусгай сантай улс орнууд өөрийн эдийн засаг, нийгмийн зорилгод нийцүүлэн тогтворжилтын, хуримтлалын, урьдчилан сэргийлэх гэсэн гурван хэлбэрийн сан байгуулж байна. Тогтворжилтын сан нь эдийн засгийг нэг салбар, нэг төрлийн бүтээгдэхүүнээс хэт хамааралтай болохоос хамгаалах, хуримтлалын сан нь ирээдүйд зориулах хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх сан нь эдийн засагт аливаа эрсдэл гарахаас хамгаалах зорилготой болно. Эдгээр сангуудад зарим орон байгалийн нөөцийн орлогоо бүхэлд нь төвлөрүүлдэг байхад зарим нь уг орлогын тодорхой хэсгийг нь төвлөрүүлж байна.

Байгалийн сэргээгдэшгүй нөөцөөс олж буй орлогыг тусгай сангаар дамжуулан менежмент хийж буй зарим орны туршлагыг дараах хүснэгтээс харж болох юм.

Хүснэгт. Сэргээгдэхгүй нөөцийн сан (NRFs)<sup>1</sup>

Тогтворжилтийн сан	Хуримтлалын сан	Урьдчилан сэргийлэх сан
Газрын тосны бүх орлогыг сандаа төвлөрүүлж улсын төсвийг хэвийн байлгахад хүрэлцэхүйц мөнгийг уг сангаасаа төсөвт өгнө. (Папау Шинэ Гвиней)	Газрын тосны орлогын тодорхой хувиар тусгай санд төвлөрүүлнэ. (Алберта, Аляска)	Газрын тосны хөгжлийн эхэн үед нийт орлогыг эсвэл зарим хэсгийг нь байгалийн нөөцийн санд төвлөрүүлэх
Төсвийн алдагдлыг санхүүжүүлнэ. Хэмнэлтийг сандаа буцаан татна. (Кувейт, Норвеги)	Засгийн газрын нийт орлогоос тодорхой хувиар тооцож тусгай санд төвлөрүүлнэ (Кувейт)	Орлого нь тооцоолсноос бага болох тохиолдолд санхүүгийн тэнцвэртэй байдлыг хадгалах зорилготой
Үнэ тодорхой хязгаараас дээш гарвал, түүнээс бий болсон орлогыг тусгай санд төвлөрүүлнэ. Үнэ уг хязгаараас доош орсон үед тусгай сангийн орлогоос төсөвт шилжүүлнэ (Чили, Венесуэл)	Нийт засгийн газрын орлого (төсвийн ашиг) (Норвеги) Төсвийн урьдчилсан төсөөллөөс илүү гарсан газрын тосны орлого (Оман)	Баялагийг үргүй цацахаас сэргийлэх  Жишээ: Азербайжан, Зүүн Тимор

<sup>1</sup> “Газрын тосны нөөцийн менежмент” уулзалтын материал, Дэлхийн Банк, НУБХХ-ийн хамтарсан Эрчим хүсний салбарын менежментийг дэмжих хөтөлбөр, 2004 оны 3 сар, 9-р хуудас.

Байгалийн сэргээгдэхгүй нөөцөөс олж буй орлогыг ирээдүйн хөгжилд түлхэц болохуйцаар ашиглах талаар олон сургамжийг дурдаж болох авч хамгийн гол нь хэтийн төлөвийг харгалзан үзэж, тогтвортой байдлыг хадгалах зарчмыг баримтлах нь чухал байна. Эс бөгөөс ихээхэн хэмжээний гэнэтийн орлого нь татварын тогтолцоо гэх мэт төрийн механизмыг хэврэгшүүлэх, эдийн засгийг цохилтод оруулах зэрэг сөрөг үр дагаврыг авч ирж болзошгүй. Эдийн засагчдын “нидерландын өвчин” хэмээн нэрлэсэн улс орны боловсруулах аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг унагаах тохиолдол ч гарч болох юм. Энэ нь “зарлагад нөлөөлөх”, “нөөцийн шилжилтийн нөлөөлөл” гэсэн 2 хэлбэрээр илэрдэг байна.

Байгалийн сэргээгдэхгүй нөөцийн орлогоос байгуулсан тусгай сангийн хөрөнгөөр олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулах замаар цэвэр, нийгмийн хариуцлагатай бизнесийг дэмжиж ашиг олох, эсвэл нийгмийн баялаг бий болгох төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг туршлага цөөнгүй байна. Үүнд Норвегийн тэтгэврийн сан, Австралийн ирээдүй сан зэрэг жишээг дурдаж болно.

### **Байгалийн сэргээгдэхгүй нөөцийн орлогоос иргэддээ хэрхэн хүртээж байна вэ?**

Улс орнууд байгалийн сэргээгдэхгүй нөөцийн орлогоос иргэддээ янз бүрийн аргаар хүртээж байгаа боловч ихэнхи нь бэлэн мөнгө тараахаас аль болохоор зайлсхийх хандлагатай байна. Бэлэн мөнгө хуваарилдаг цөөхөн улс орон байгаа бөгөөд тэдгээрийн зарим нь тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон ашгийг ногдол ашиг хэлбэрээр иргэддээ хуваарилах аргыг, зарим нь байгалийн нөөцийн орлогоо шууд хуваарилах аргыг хэрэглэж байна. Жишээ нь, АНУ-ын Аляск муж улс ногдол ашиг хуваарилдаг ажээ. Аляскийн байнгын сангийн корпораци 1976 оноос үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус сангаас санхүүгийн гадаад зах зээл дээр үйл ажиллагаа явуулж олсон ашгийнхаа тодорхой хувийг бүх иргэддээ ногдол ашиг болгон хуваарилж байна. Тэгвэл Венесуэл улс байгалийн нөөцийн орлогоо иргэддээ бэлэн мөнгөөр шууд тараах хэлбэрийг ашиглажээ. Өөрөөр хэлбэл, Венесуэл улс байгалийн нөөцийн орлогыг хөрөнгө оруулалт болон хуримтлалын аль алинд зарцуулалгүй нийгмийн халамжаар дамжуулан ард иргэддээ тараасан ажээ. Эндээс авах гол сургамж гэвэл хичнээн бэлэн мөнгө тараагаад Венесуэл 3 сая ядуучуудаа ядуурлаас гаргаж чадаагүй гэнэ.

Бусад улс орнуудын хувьд байгалийн нөөцийн орлогоо бүрэн болон хэсэгчилсэн хэлбэрээр тусгай санд төвлөрүүлж, уг сангийн үйл ажиллагаанаас олсон ашгаас улс орны өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд янз бүрийн арга хэрэгсэлээр дамжуулан зарцуулж байна. Тухайлбал, Австрали, Норвеги улс, байгуулсан сангийнхаа хөрөнгийг ирээдүйд төсөв дээр ирэх тэтгэврийн зардлыг санхүүжүүлэхэд зориулан хуримтлуулж байхад Казакстан улс ирээдүйн хөгжлийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэхэд зориулан хадгалж байна. Канад улсын Алберто муж нийтийн эрх ашгийн төлөө үйлчлэх тодорхой төслийг санхүүжүүлэх замаар хүн амын амьжиргаанд дэмжлэг үзүүлэхэд ашигладаг ажээ. Канадын Алберто мужийн сангаас санхүүжүүлсэн төслүүдийн зарим нь манай өнөөгийн нийгмийн эрэлт хэрэгцээтэй нилээд төстэй байгааг дурдах нь зүйтэй юм. Тухайлбал, мужийн эмнэлэгийн судалгаа шинжилгээний өвийн сан, гэр бүлийг дэмжих ба хүчирхийллийн эсрэг сан, мужийн хүүхдийн нэгдсэн эмнэлэг байгуулах, ойжуулалт болон ойн арчилгааны ажлыг өргөжүүлэх, хорт хавдартай тэмцэх судалгаа, шинжилгээний ажил, сэргээгдэх эрчим хүчний судалгааны ажил зэрэг төслүүдийг уг сангаас санхүүжүүлсэн байна.

Монгол Улс байгалийн нөөцийн орлогоо зохистой ашиглах тал дээр анхны алхамаа хийгээд байна. Улсын их хурлаас 2007 оны 2 сарын 6-ны өдөр “Монгол улсыг хөгжүүлэх сангийн тухай” хуулийг батлан гаргаж, уг санд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлогын тодорхой хэсэг, Монгол улсын нэгдсэн төвсийн тухай хуульд заасны дагуу “Санхүүгийн тайлант жилийн улсын тйсвийн зарлагаас давсан орлого буюу улсын төсвийн ашиг, эрсдэлийн сангийн зарцуулагдаагүй хөрөнгө”-өөс, мөн сангийн хөрөнгийн үлдэгдэлд төлсөн хүүгийн орлого болон бусад орлогыг төвлөрүүлэхээр заажээ. Энэхүү санг:

- улс орныг бүхэлд нь хамарсан гамшиг тохиолдсон, эсхүл бүтээгдэхүүний ашигт малтмалын дэлхийн зах зээл дэх үнэ огцом буурснаас улсын төсвийн орлого буурч, Засгийн газар бүх нөөцөө дайчилсны дараа төсвийн орлогын дутагдал нөхөгдөөгүй тохиолдолд буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн төсвийн орлогын дутагдлыг нөхөх;
- улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, жижиг, дунд бизнес / аж ахуйн үйл ажиллагаа/-ийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх;
- хүүхэд, гэр бүлийг дэмжихэд зориулан ашиглахаар хуульчилсан байна.

Монгол улсыг хөгжүүлэх сан нь тогтворжуулах болон урьдчилан сэргийлэх зорилготой сан юм. Түүнчлэн уг сангаас хүүхэд бүрт жил бүр 100000 төгрөг олгож байгаа нь байгалийн нөөцийн орлогоос хишиг хүртээж буй хэлбэр юм. Гэхдээ энэхүү хишиг хүртээдэг явдал цаашид өргөжвөл Венесуэл зэрэг орны таагүй сургамжийг давтах магадлалтай учраас байгалийн сэргээгдэхгүй нөөцийн орлогоос хуримтлалын сан байгуулах замаар нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал чухал болж байна. Иймээс Засгийн газраас Эх орны хишиг сангийн тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн бариад байгаа билээ.

Хэрвээ энэ хууль батлагдан гарвал Эх орны хишиг санд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг; стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн улсын төсөвт төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 25 хувь болон уг хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсгийн 50 хувийг тус тус төвлөрүүлэн санхүүгийн гадаад зах зээл дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж түүнээс олсон ашгаасаа иргэддээ хүртээх, нийтийн эрх ашгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх юм. Түүнчлэн уг сангаас иргэдэд түгээх хишгийг эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах эрхийн бичиг; орон сууцны зээлийн төлбөр; бүх төрлийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр; стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглаж байгаа хуулийн этгээдийн давуу эрхийн хувьцаа; Засгийн газрын өрийн бичиг; банкинд хадгаламж зэрэг бэлэн бус тооцооны хэлбэр, бодит үйлчилгээгээр хүргэхээр тусгаад байна.

# Асуувал?

## Хариулъя...

**Асуулт 1. Нийгмийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ буурч, ажилтных нэмэгдсэн гэх юм. Энэ үнэн үү?**

**Хариулт 1.** Нийгмийн даатгалын багц хуулинд орсон нэмэлт өөрчлөлтөөр ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ ажилтанд төлж буй хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 19-21 хувь байсныг 10-13 хувь болгон бууруулжээ. Харин ажилтны нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг даатгалын төрөл тус бүрээр шинэчлэн тогтоохдоо тэтгэврийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг өмнөхөөс нь 1,5 пунктээр нэмэгдүүлсэн боловч бусад төрлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулсан учраас нийт дүнгээрээ нэмэгдээгүй байна.

Та болон таны ажил олгогч нийгмийн даатгалд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо хэдэн хувиар шимтгэл төлж байсан болон одоо хэдэн хувиар төлөх болсныг дараах хүснэгтээс харж болно.

Нийгмийн даатгалын төрөл	Өмнө нь		2008 оны 1 сарын 1-нээс шинэчлэгдсэн нь		Сайн дурын даатгуулагч
	Ажил олгогч	Даатгуулагч	Ажил олгогч	Даатгуулагч	
Тэтгэврийн даатгал	13.5	5.5	7.0	7.0	10.0
Тэтгэмжийн даатгал	1.0	1.0	0.5	0.5	1.0
ҮОМШӨ-ний даатгал	1.0 – 3.0	-	1.0 - 3.0	-	1.0
Эрүүл мэндийн даатгал	3.0	3.0	2.0	2.0	-
Ажилгүйдлийн даатгал	0.5	0.5	0.5	0.5	
Нийт	19.0-21.0	10.0	11.0-13.0	10.0	12.0

Эрүүл мэндийн даатгалд ажиллагчдаас гадна хүн амын янз бүрийн бүлэг хамрагддаг юм. Эдгээрийн заримынх нь шимтгэлийг төр хариуцдаг, зарим орлогын байнгын тогтвортой эх үүсвэргүй хэсэг нь орлогынхоо хувиар бус, тогтоосон тарифаар шимтгэл төлдөг зэрэг онцлогтой. Эрүүл мэндийн даатгалд хэн хэдий хэмжээний шимтгэл төлж байгааг харуулав.

Даатгуулагчийн төрөл	Шимтгэл хувь, төлбөрийн хэмжээ
Ажил олгогч	2% /цалингийн/
Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан	2% /цалингийн/
Малчин, оюутан, хувиараа хөдөлмөр эрхлээгүй иргэд,	500 төгрөг /сард/
Төр хариуцдаг иргэд,	500 төгрөг /сард/
Гадаадын иргэн, харьяалалгүй иргэд	4000 төгрөг /сард/

**Асуулт 2. БНСУ-д ажиллах хүч гаргахаар “Гадаадад ажиллах хүч илгээх төв” гэж байгуулагдан, их олон хүн бүртгэж авсан. Энэ төвд бүртгүүлсэн хүмүүсээс хэдэн хүн яваад байгаа вэ? Солонгосын ажил олгогчид нэрээ өгч урилга авах боломжтой юу?**

**Хариулт 2.** Засгийн газрын 2007 оны 36 дугаар тогтоол, Төрийн өмчийн Хорооны 2007 оны 88 дугаар тогтоолын дагуу “Гадаадад ажиллах хүч илгээх төв” ХХК-ийг үүсгэн байгуулж, БНСУ-д ажиллах хүч илгээх үйл ажиллагааг зохион байгуулж байна. 2007 онд нийт 15000 иргэнийг хүсэлтийг харгалзан бүртгэсэн бөгөөд дараах байдлаар хөдөлмөрийн биржид байршсан байна.

БНСУ-ын хөдөлмөрийн биржид байршуулсан иргэдийн тухай мэдээлэл				
Салбар	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Зуучлагдсан байдал байдал (%-аар)
Хөдөө аж ахуй	2296	1482	3778	4,0
Барилга	1186	18	1204	
Загасны аж ахуй	91	90	181	48,6
Үйлдвэр	3066	2477	5543	43,5
Хөргөх байгууламж	504	12	516	5,6
Нийт	7143	4079	11222	23,9

Ийнхүү байршуулсан хүмүүсээс солонгосын талын ажил олгогч аль салбарт, ямар чиглэлээр, хир зэрэг цалин хангамжтай ажиллах хүсэлтэй зэргийг нь харгалзан сонголт хийж, ажлын саналыг тухайн сонгосон хүнийхээ нэр дээр ирүүлнэ. Хэрвээ тухайн хүн энэхүү

ирсэн ажлын санал, хөдөлмөрийн нөхцөлийг зөвшөөрвөл хөдөлмөрийн гэрээ байгуулан БНСУ-д очиж ажиллах боломжтой болдог юм. Дээрх 15000 хүнээс 2007 онд 2683 хүн буюу БНСУ-ын Хөдөлмөрийн биржид байршигчдын 23.9 хувь нь ажил олгогчтойгоо гэрээгээ байгуулаад зохих журмын дагуу явсан байна. Солонгосын талаас хөдөлмөрийн гэрээний санал ирсний үндсэн дээр ажилд зуучлагддаг бөгөөд ямар нэг урилга ирдэггүй гэдгийг анхаарвал зохино.

***Асуулт 3. Өнгөрсөн 2007 оныг Засгийн газраас Их бүтээн байгуулалт, ажлын байр нэмэгдүүлэх жил болгон зарласан. Энэ ажил ямар үр дүнд хүрсэн бэ? Аль салбарт ажлын байр түлхүү бий болов?***

**Хариулт 3.** “Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх” жилд 80000-аас доошгүй ажлын байр шинээр бий болгох зорилт дэвшүүлэн ажилласан юм. Засгийн газраас эрчим хүч, зам зэрэг дэд бүтцийн салбарт улсын төсвөөр хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг бууруулах, иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг өргөжүүлэх зэрэг бизнесийн үйл ажиллагааг дэмжих багц арга хэмжээ авсаны үр дүнд өнгөрсөн онд аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд 81172 шинэ ажлын байр бүртгэгдсэн байна. Эдгээрийн 36792 нь Улаанбаатар хотод, 44380 нь аймаг орон нутагт бий болсноос гадна 75.2 хувь нь байнгын, 24,8 хувь нь улирлын чанартай байна. Шинээр бий болсон ажлын байрын 11 хувь нь хөдөө аж ахуйд, 6,6 хувь нь уул уурхайд, 13,3 хувь нь боловсруулах үйлдвэрт, 23,1 хувь нь барилгын салбарт бий болжээ. Энэ нь эдгээр салбар өсөлттэй, ажиллах хүчний эрэлттэй байгааг харуулж байна.

Редакцийн зөвлөл

Н.Аюуш /Мэдээлэл, судалгаа,  
үнэлгээний газрын дарга/

Т.Эрдэнэ /Төрийн захиргааны, удирдлагын  
газрын орлогч дарга /

Ш.Отгонхундага /Хүн амын хөгжил,  
нийгмийн бодлого  
зохицуулалтын газрын  
орлогч дарга/

Б.Алимаа /Хөдөлмөрийн бодлого  
зохицуулалтын газрын  
орлогч дарга/

Ж.Ням-Осор /Санхүү, эдийн засгийн  
хэлтсийн дарга/

Б.Эрдэнэбулган /Гадаад хамтын  
ажиллагааны хэлтсийн  
дарга/

*Эхийг Нийгмийн Хамгаалал,  
Хөдөлмөрийн Яамны Мэдээлэл, Судалгаа  
Үнэлгээний Газарт бэлтгэв*